



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/М/5

Мянсазговь

Тусгай зөвшөөрлийн эрх сунгах
тухай

Монгол Улсын "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.2, 7.4, 9 дүгээр зүйлийн 9.1.2, 16 дугаар зүйлийн 16.2.5 дахь заалт, "Архидан согтуурахтай тэмцэх тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалт, 7 дүгээр зүйлийн 7.1.7, 7.1.8, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Өлзийт, Сайхан-Овоо сумдын "Цант Өлзийт", "Сэрүүн онги" ХХК-ны хүнсний дэлгүүрүүдэд согтууруулах ундаа худалдах, Гурвансайхан сумын "Давших зам" хоршооны караоке бааранд согтууруулах ундаагаар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн эрхийг 2018 оны 03 дугаар сарын 21-ны өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 21-ны өдөр хүртэл хугацаагаар олгосугай.

Хоёр. Тусгай зөвшөөрлийн эрх олгогдсон "Цант-Өлзийт", "Сэрүүн онги" ХХК-ны хүнсний дэлгүүрийн ажиллах цагийн хуваарийг 09.00-20.00, "Давших зам" ХХК-ны караоке баарны ажиллах цагийн хуваарийн хязгаарыг 09.00-24.00 хүртэл баталсугай.

Гурав. Тусгай зөвшөөрлийн эрхийг олгосон шийдвэрийг холбогдох газруудад хуулийн хугацаанд мэдэгдэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Н.Эрдэнэ-Очир/, тухайн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар /М.Ганбаатар/, Татварын хэлтэс /М.Туяацэцэг/, Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ

0200373